



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 38 (175)

Монгол Улсын хууль:

- *Конвенци соёрхон батлах тухай*

Монгол Улсын Их Хурлын тогтоол:

- *Нөхөн олговрын доод хэлжээг шинэчлэн тогтоох тухай*

Яам агентлагийн акт:

- *Сангийн сайд, Эрүүл мэнд, нийгмийн хатгааллын сайдын хамтарсан тушаал*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2000 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2000 оны аравдугаар сарын 13

№38 (175)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

403. Конвенци соёрхон батлах тухай

404. Конвенци соёрхон батлах тухай

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

405. Нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн
тогтоох тухай

Дугаар 35

Гурав. ЯАМ, АГЕНТЛАГИЙН АКТ

406. Сангийн сайд, Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын
сайдын хамтарсан тушаал

Дугаар 28/59

407. Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайд,
Хууль зүйн сайдын хамтарсан тушаал

Дугаар 19/04/12

408. Монгол Улсын Сангийн сайдын тушаал

Дугаар 64

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 10 дугаар
сарын 5-ны өдөр

Улаанбаатар
хот

Конвенци соёрхон батлах тухай

1 дүгээр зүйл. Женев хотноо 1999 оны 6
дугаар сарын 17-ны өдөр батлагдсан Олон Улсын
Хөдөлмөрийн байгууллагын "Хүүхдийн
хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох, нэн
даруй устгах тухай" 182 дугаар Конвенцийг Засгийн

газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА

Л. ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 10 дугаар
сарын 5-ны өдөр

Улаанбаатар
хот

Конвенци соёрхон батлах тухай

1 дүгээр зүйл. 1998 оны 9 дүгээр сарын 18-
ны өдөр байгуулсан "Аюултай зарим химийн бодис
болон пестицидийг олон улсын хэмжээнд
худалдаалахад хэрэглэх, урьдчилан мэдээлж
зөвшилцөх журмын тухай Роттердамын Конвенци"-

ийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон
баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА

Л. ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 10 дугаар сарын 5-ны өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Нөхөн олговрын талаар зарим арга хэмжээ авах болон нөхөн олговрын доод хэмжээг тогтоох тухай Улсын Их Хурлын 1999 оны 24 дүгээр тогтоолын 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Тэтгэвэр нь түр зогсоогдсон иргэдийн авч байгаа нөхөн олговрын доод хэмжээг сард 16000 төгрөгөөр тогтоож, 2000 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн олгосугай.

2. Үүнтэй холбогдуулан Нөхөн олговрын талаар зарим арга хэмжээ авах болон нөхөн олговрын доод хэмжээг тогтоох тухай Улсын Их Хурлын 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 24 дүгээр тогтоолын 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
Л. ЭНЭБИШ

МОНГОЛ БАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, САНГИЙН САЙД, ХУУЛЬ ЗҮЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2000 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр

Дугаар 19/04/12

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын 1999 оны 203 дугаар тогтоолыг үндэслэн **ТУШААХ** нь:

"Шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагаас банкны зээлийн хугацаа хэтэрсэн өр барагдуулах замаар хуримтлуулсан хөрөнгийн тодорхой хувийг төвлөрүүлэх, зарцуулах,

тайлагнах журам"-ыг хэвсгалтын ёсоор баталсугай.

**Монголбанкны ерөнхийлөгч
Сангийн сайд
Хууль зүйн сайд**
**Ж.ҮНЭНБАТ
Я.ОЧИРСҮХ
Даш.ГАНБОЛД**

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Хууль зүйн сайдын 2000 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 19/04/12 дугаар хамтарсан тушаалын хэвсгалт

ШҮҮХ, ПРОКУРОР, ЦАГДАА, ШҮҮХИЙН ШИЙДВЭР БИЕЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГААС БАНКНЫ ЗЭЭЛИЙН ХУГАЦАА ХЭТЭРСЭН ӨР БАРАГДУУЛАХ ЗАМААР ХУРИМТЛУУЛСАН ХӨРӨНГИЙН ТОДОРХОЙ ХУВИЙГ ТӨВЛӨРҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Банкны зээлийн хугацаа хэтэрсэн өр барагдуулах ажлыг эрчимжүүлэх тухай Засгийн газрын 1999 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 203 дугаар тогтоолд заасны дагуу шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагаас /цаашид "хуулийн байгууллага" гэнэ/ эрх хэмжээнийхээ хүрээнд банкны зээлийн хугацаа хэтэрсэн өр барагдуулах замаар хуримтлуулсан хөрөнгийн 10 хүртэлх хувийг Монголбанк дахь тусгай дансанд төвлөрүүлж зарцуулах, тайлагнахад энэ журмыг мөрдөнө.

2. Хуулийн байгууллагаас банкны зээлийн хугацаа хэтэрсэн өр барагдуулах замаар хуримтлуулсан хөрөнгөд дээрх байгууллагуудаас банкуудтай гэрээ байгуулах замаар барагдуулсан дараахь хөрөнгө

хамаарна. Үүнд:

1/ хугацаа хэтэрсэн зээлийн төлбөр гаргуулах тухай прокурорын болон банкны нэхэмжлэлийг хангаж гаргасан шүүхийн шийдвэрт гүйцэтгэх хуудас бичиж төлүүлсэн мөнгө;

2/ прокурорын байгууллагаас шаардаж төлүүлсэн зээлийн төлбөр;

3/ цагдаагийн байгууллагаас шаардаж төлүүлсэн зээлийн төлбөр;

4/ шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагаас гүйцэтгэж төлүүлсэн зээлийн төлбөр.

3. Банкны зээлийн хугацаа хэтэрсэн өр барагдуулах ажлыг эрчимжүүлэх ажлын хэсэгтэй /цаашид "Ажлын хэсэг" гэнэ/ гэрээ байгуулсан банкны дансанд тодорхой зээл болон бусад



авлагын төлбөр ормогц түүний гэрээнд заасан хувийг Монголбанкны холбогдох дансанд шилжүүлж төвлөрүүлнэ.

Харин өргөн хэрэгцээний бараа болон машин, тоног төхөөрөмж, байшин, түүхий эд зэрэг бусад эд хөрөнгөөр зээлийн хугацаа хэтэрсэн өрийг барагдуулсан бол түүнийг борлуулсны дараа зохих хувийг төвлөрүүлэх арга хэмжээ авна.

4. Тусгай дансанд төвлөрсөн дээрх хөрөнгийг хуваарилахдаа Ажлын хэсгийн саналыг үндэслэн хуулийн байгууллагууд /шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага/-ын удирдлага /ерөнхий шүүгч, ерөнхий прокурор, дарга/-ын тохиролцсоноор Монголбанк дахь тусгай данснаас тодорхой хувиар зохих байгууллагын дансанд шилжүүлнэ.

5. Гадаад, дотоодын байгууллага, иргэдээс санаачилга гарган хуулийн байгууллагуудын дээрх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор хандив, тусламж үзүүлэх тохиолдолд энэ журмын 3 дахь хэсэгт заасан дансанд шилжүүлнэ.

6. Монголбанк дахь тусгай дансны гүйлгээний баримтад нэгдүгээр гарын үсгийг Хууль зүйн сайд, хоёрдугаар гарын үсгийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн нягтлан бодогч зурна.

Хоёр. Хөрөнгийн зарцуулалт

7. Монголбанк дахь тусгай дансанд төвлөрүүлсэн мөнгийг Ажлын хэсгийн саналыг үндэслэн Хууль зүйн сайд дараахь зориулалтаар зарцуулна:

- 1/ тухайн байгууллагын үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах;
- 2/ техник хангамжийг сайжруулах;
- 3/ боловсон хүчнийг сургах, давтан бэлтгэх;
- 4/ ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх;
- 5/ бусад зардал.

8. Тусгай дансанд төвлөрсөн хөрөнгөөс Ажлын хэсгийн гишүүдийг урамшуулах болон үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлж болно.

9. Тусгай дансанд төвлөрсөн хөрөнгийг энэ журмын 7,8 дахь хэсэгт зааснаас бусад зориулалтаар зарцуулах, уг хөрөнгө олгогдоогүй байхад урьдчилан зардал гаргахыг хориглоно.

Гурав. Хөрөнгийг тайлагнах журам

10. Тусгай дансанд төвлөрүүлж, хуулийн байгууллагуудад олгосон хөрөнгийн тайланг тухайн байгууллага энэ журамд заасан маягтын дагуу сар бүр гаргаж, холбогдох санхүүгийн байгууллага болон Монголбанкинд дараа сарын 15-ны дотор хургүүлнэ.

САРЫН ТАЙЛАН

/Мян.төг/

№	Үзүүлэлт	Төлөөлөгөө	Гүйцэтгэл
1.	Орлогын дүн: Үүнээс: 1/ эхний үлдэгдэл 2/ банкнаас шилжүүлсэн 3/ хандив, тусламжаар орсон		
2.	Зарлагын дүн Үүнээс: 1/ үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангахад 2/ техник, тоног төхөөрөмжид 3/ боловсон хүчний сургалтад 4/ ажилтны нийгмийн асуудалд 5/ ажлын хэсгийн үйл ажиллагааны зардалд 6/ бусад зардалд		
3.	Эцсийн үлдэгдэл		

Тайлан гаргасан: Байгууллагын дарга.....
Нягтлан бодогч.....

11. Зохих хуулийн байгууллагад оруулсан хөрөнгийн зарцуулалтад Сангийн яамны дэргэдэх Санхүүгийн хяналтын алба Монголбанкны хяналт шалгалтын газартай хамтран хяналт тавина.

12. Тухайн жилийн эцэст тусгай дансанд үлдсэн

хөрөнгийг дараа жилийн тооцоонд оруулна.

13. Тайлангийн хугацаанд хүлээсэн үүргээ биелүүлээгүй, журмын 10 дугаар зүйлд заасан тайланг саатуулсан хүмүүст холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

САНГИЙН САЙД, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2000 оны 2 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 28/59

Улаанбаатар хот

Тариф шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4, 6 дахь хэсгийг үндэслэн **ТУШААХ** нь:

1. Даатгуулагчийн эмчилгээний хувьсах зардлыг эрүүл мэндийн даатгалын төвлөрсөн болон орон нутгийн сан, даатгуулагч өөрөө төлөх төлбөрийн тарифыг 1 дүгээр хавсралтын ёсоор, Эмчийн заалтаар орон нутгийн эмнэлгээс улсын хэмжээний үйлчилгээтэй эмнэлэгт шилжин эмчлүүлэх даатгуулагчийн эмчилгээний хувьсах зардалд Эрүүл мэндийн даатгалын төвлөрсөн сангаас төлөх хөрөнгийн лимитийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тушаалыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар /Ц.Сүхбаатар/, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газ-

рын дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Мэдээлэл, хяналт, шинжилгээ, үнэлгээний газар /Ц.Даваасүрэн/, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны Мэдээлэл, мониторингийн газар /П.Алтанхуяг/-т тус тус даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Сангийн сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1998 оны А/358/359 тоот тушаалын 3.4 дүгээр хавсралтыг хүчингүй болгонд тооцсугай.

Сангийн сайд
Эрүүл мэнд, Нийгмийн
хамгааллын сайд

Я.ОЧИРСҮХ
С.СОНИН

Сангийн сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 28/59 тоот хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт

ДААТГУУЛАГЧИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ХУВЬСАХ ЗАРДЛЫГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТӨВЛӨРСӨН БОЛОН ОРОН НУТГИЙН САН, ДААТГУУЛАГЧ ӨӨРӨӨ ТӨЛӨХ ТӨЛБӨРИЙН ТАРИФ

№	Эмчилгээний ангилал	Хэмжээ нэгж	Тариф /өвгөрөг/	Үнэмлэх		Даатгуулагч өөрийн хэсэг
				ЭМД-ын төвлөрсөн сан төмөр	ЭМД-ын орон нутгийн сан төмөр	
1	Клиникийн I, II, III эмнэлэг, Гэмтэл согоогийн клиникийн эмнэлэг	нэг эмчлүүлэгч	31,000	45,900	х	5,100
2	Эх нэгжсэн эрдэм шинжилгээний төв, Хавар судлалын төв, Эвсэгт хүчлэй клиникийн төв эмнэлэг	нэг эмчлүүлэгч	47,000	42,300	х	4,700
3	Халдарт, Арьс өнгө, Сүтээлийн болон Уламжлалт ангиаг уршмын клиникийн эмнэлэг, төв	нэг эмчлүүлэгч	36,000	32,400	х	3,600
4	Амин, дүүргийн нэгжсэн эмнэлэг	нэг эмчлүүлэгч	45,000	х	40,500	4,500
5	Төмөр замын, Хормоны нэгжсэн эмнэлэг	нэг эмчлүүлэгч	45,000	40,500	х	4,500
6	I амьдрал газрын эмчлүүлэгчдийн тасаг	нэг эмчлүүлэгч	30,000	х	27,000	3,000
7	Хүүхдийн эмнэлэг, Сэргэн засах клиникийн эмнэлэг, адилтгаа бусад эмнэлэг	нэг эмчлүүлэгч	32,000	х	28,800	3,200
8	Сум дундын эмнэлэг	нэг эмчлүүлэгч	25,000	х	22,500	2,500
9	Сум хорооны эмнэлэг	нэг эмчлүүлэгч	22,000	х	19,800	2,200
10	Хормоны, Шүргийн, Халдарт шүргийн ангийн салбар эмнэлэг	нэг эмчлүүлэгч	12,700	х	11,430	1,270
11	Раван сувгаал* а. Оргил	нэг эмчлүүлэгч	19,000	19,000	х	х
11	б. Орон нутаг дахь улсын үйлчилгээтэй раван сувгаал	нэг эмчлүүлэгч	14,000	14,000	х	х
12	Раван сувгаалын клиник тасаг	нэг эмчлүүлэгч	21,000	21,000	х	х
13	Тазар дутуу иргэдийн мэргэжлийн сургаал үндэсний төвийн клиник тасаг	нэг эмчлүүлэгч	20,000	х	20,000	х



авлагын төлбөр ормогц түүний гэрээнд заасан хувийг Монголбанкны холбогдох дансанд шилжүүлж төвлөрүүлнэ.

Харин өргөн хэрэгцээний бараа болон машин, тоног төхөөрөмж, байшин, түүхий эд зэрэг бусад эд хөрөнгөөр зээлийн хугацаа хэтэрсэн өрийг барагдуулсан бол түүнийг борлуулсны дараа зохих хувийг төвлөрүүлэх арга хэмжээ авна.

4. Тусгай дансанд төвлөрсөн дээрх хөрөнгийг хуваарилахдаа Ажлын хэсгийн саналыг үндэслэн хуулийн байгууллагууд /шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага/-ын удирдлага /ерөнхий шүүгч, ерөнхий прокурор, дарга/-ын тохиролцооноор Монголбанк дахь тусгай данснаас тодорхой хувиар зохих байгууллагын дансанд шилжүүлнэ.

5. Гадаад, дотоодын байгууллага, иргэдээс санаачилга гарган хуулийн байгууллагуудын дээрх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор хандив, тусламж үзүүлэх тохиолдолд энэ журмын 3 дахь хэсэгт заасан дансанд шилжүүлнэ.

6. Монголбанк дахь тусгай дансны гүйлгээний баримтад нэгдүгээр гарын үсгийг Хууль зүйн сайд, хоёрдугаар гарын үсгийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн нягтлан бодогч зурна.

Хоёр. Хөрөнгийн зарцуулалт

7. Монголбанк дахь тусгай дансанд төвлөрүүлсэн мөнгийг Ажлын хэсгийн саналыг үндэслэн Хууль зүйн сайд дараахь зориулалтаар зарцуулна:

- 1/ тухайн байгууллагын үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах;
- 2/ техник хангамжийг сайжруулах;
- 3/ боловсон хүчнийг сургах, давтан бэлтгэх;
- 4/ ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх;
- 5/ бусад зардал.

8. Тусгай дансанд төвлөрсөн хөрөнгөөс Ажлын хэсгийн гишүүдийг урамшуулах болон үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлж болно.

9. Тусгай дансанд төвлөрсөн хөрөнгийг энэ журмын 7,8 дахь хэсэгт зааснаас бусад зориулалтаар зарцуулах, уг хөрөнгө олгогдоогүй байхад урьдчилан зардал гаргахыг хориглоно.

Гурав. Хөрөнгийг тайлагнах журам

10. Тусгай дансанд төвлөрүүлж, хуулийн байгууллагуудад олгосон хөрөнгийн тайланг тухайн байгууллага энэ журамд заасан маягтын дагуу сар бүр гаргаж, холбогдох санхүүгийн байгууллага болон Монголбанкинд дараа сарын 15-ны дотор хүргүүлнэ.

САРЫН ТАЙЛАН

/Мян.төг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1.	Орлогын дүн:		
	Үүнээс:		
	1/ эхний үлдэгдэл		
	2/ банкнаас шилжүүлсэн		
	3/ хандив тусламжаар орсон		
2.	Зарлагын дүн		
	Үүнээс:		
	1/ үйл ажиллагааны хэвийн нөхцлийг хангахад		
	2/ техник, тоног төхөөрөмжид		
	3/ боловсон хүчний сургалтад		
	4/ ажилтны нийгмийн асуудалд		
	5/ ажлын хэсгийн үйл ажиллагааны зардалд		
	6/ бусад зардалд		
3.	Эцсийн үлдэгдэл		

Тайлан гаргасан: Байгууллагын дарга.....
Нягтлан бодогч.....

11. Зохих хуулийн байгууллагад оруулсан хөрөнгийн зарцуулалтад Сангийн яамны дэргэдэх Санхүүгийн хяналтын алба Монголбанкны хяналт шалгалтын газартай хамтран хяналт тавина.

12. Тухайн жилийн эцэст тусгай дансанд үлдсэн

хөрөнгийг дараа жилийн тооцонд оруулна.

13. Тайлангийн хугацаанд хүлээсэн үүргээ биелүүлээгүй, журмын 10 дугаар зүйлд заасан тайланг саатуулсан хүмүүст холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

САНГИЙН САЙД, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2000 оны 2 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 28/59

Улаанбаатар хот

Тариф шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4, 6 дахь хэсгийг үндэслэн **ТУШААХ** нь:

1. Даатгуулагчийн эмчилгээний хувьсах зардлыг эрүүл мэндийн даатгалын төвлөрсөн болон орон нутгийн сан, даатгуулагч өөрөө төлөх төлбөрийн тарифыг 1 дүгээр хавсралтын ёсоор, Эмчийн заалтаар орон нутгийн эмнэлгээс улсын хэмжээний үйлчилгээтэй эмнэлэгт шилжин эмчлүүлэх даатгуулагчийн эмчилгээний хувьсах зардалд Эрүүл мэндийн даатгалын төвлөрсөн сангаас төлөх хөрөнгийн лимитийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тушаалыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар /Ц.Сүхбаатар/, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газ-

рын дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Мэдээлэл, хяналт, шинжилгээ, үнэлгээний газар /Ц.Даваасүрэн/, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны Мэдээлэл, мониторингийн газар /П.Алтанхуяг/-г тус тус даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Сангийн сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1998 оны А/358/359 тоот тушаалын 3,4 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

Сангийн сайд
Эрүүл мэнд, Нийгмийн
хамгааллын сайд

Я.ОЧИРСҮХ
С.СОНИН

Сангийн сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 28/59 тоот хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт

ДААТГУУЛАГЧИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ХУВЬСАХ ЗАРДЛЫГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТӨВЛӨРСӨН БОЛОН ОРОН НУТГИЙН САН, ДААТГУУЛАГЧ ӨӨРӨӨ ТӨЛӨХ ТӨЛБӨРИЙН ТАРИФ

Эмчилгэйн ангилал	Хажих хэрг	Тариф /гажиг/	Үнэмлэх		
			ЭМД-ийн төвлөрсөн сан төлөх	ЭМД-ийн орон нутгийн сан төлөх	Даатгуулагч өөрөө төлөх
1. Клиникийн I, II, III эмнэлэг, Гянтал согогийн клиникийн эмнэлэг	нэг эмчлүүлэгч	51,800	45,900	х	5,100
2. Эх явцсын эрдэм шинжилгээний төв, Хөвдөр судаллын төв, Зэвсэгт хүчний клиникийн төв эмнэлэг	нэг эмчлүүлэгч	47,600	42,300	х	4,700
3. Хэдлэрт, Арьс өнгө, Сэтгэцийн болон Уламжлалт ангиат уламжлалын клиникийн эмнэлэг, төв	нэг эмчлүүлэгч	36,000	32,400	х	3,600
4. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг	нэг эмчлүүлэгч	45,000	х	40,500	4,500
5. Төмөр замын, Хормоны нэгдсэн эмнэлэг	нэг эмчлүүлэгч	45,000	40,500	х	4,500
6. Гаврижиг газрын эмгэгтүүрхдийн тасаг	нэг эмчлүүлэгч	30,000	х	27,000	3,000
7. Хүүхдийн эмнэлэг, Сэргэн засах клиникийн эмнэлэг, адилтга бусад эмнэлэг	нэг эмчлүүлэгч	32,000	х	28,800	3,200
8. Сум дундын эмнэлэг	нэг эмчлүүлэгч	25,000	х	22,500	2,500
9. Сум хорооны эмнэлэг	нэг эмчлүүлэгч	22,000	х	19,800	2,200
10. Хормоны, Цэргийн, Хөлийн цэргийн ангийн салбар эмнэлэг	нэг эмчлүүлэгч	12,700	х	11,430	1,270
11. Рашин сувилал* а. Оргод б. Орон нутаг дахь улсын үйлчлэгчтэй рашин сувилал	нэг эмчлүүлэгч	19,000	19,000	х	х
12. Рашин сувилалын клиник тасаг	нэг эмчлүүлэгч	14,000	14,000	х	х
13. Рашин сувилалын клиник тасаг	нэг эмчлүүлэгч	21,000	21,000	х	х
14. Тазар дутуу иргэдийн нэвгэрлэлийн сургалт үндэснэгдийн төвийн клиник тасаг	нэг эмчлүүлэгч	20,000	х	20,000	х

4	1. Шүүрхэн тугуур хэвний зэвчлэг	нж бүрэн зэвчлэг	500	x	500	x
	2. Шүүрхэн тугуур хэвний зэвчлэг		2,400	x	2,400	x
	3. Шүүрхэн тугуур хэвний зэвчлэг		4,000	x	4,000	x
	4. Шүүрхэн тугуур хэвний зэвчлэг		4,500	x	4,500	x
5	Эмчлэгчүүдийн багийн замын зонхлон төлөөлөгч үүрэгт өмчийн зэвчлэг	нж бүрэн зэвчлэг	3,500	x	3,500	x

*-Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох хөрөнгийн хэмжээ

Сангийн сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 28/59 тоот хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт

ЭМЧИЙН ЗААЛТААР ОРОН НУТГИЙН ЭМНЭЛГЭЭС УЛСЫН ХЭМЖЭЭНИЙ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ЭМНЭЛЭГТ ШИЛЖИН ЭМЧЛҮҮЛЭХ ДААТГУУЛАГЧИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ХУВЬСАХ ЗАРДАЛД ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТӨВЛӨРСӨН САНГААС ТӨЛӨХ ХӨРӨНГИЙН ЛИМИТ

	Аймаг, хотын нэр	Хөрөнгийн лимит /мянган төгрөг/
1	Архангай	50,000.0
2	Баян-Өлгий	15,000.0
3	Баянхонгор	30,000.0
4	Булган	40,000.0
5	Говь-Алтай	30,000.0
6	Дорноговь	50,000.0
7	Дорнод	35,000.0
8	Дундговь	40,000.0
9	Завхан	45,000.0
10	Өвөрхангай	45,000.0
11	Өмнөговь	30,000.0
12	Сүхбаатар	35,000.0
13	Сэлэнгэ	90,000.0
14	Төв	185,000.0
15	Увс	35,000.0
16	Ховд	30,000.0
17	Хөвсгөл	35,000.0
18	Хэнтий	60,000.0
19	Дархан-Уул	55,000.0
20	Орхон	40,000.0
21	Говь-Сүмбэр	25,000.0
22	Улаанбаатар	2,000,000.0
	ДҮН	3,000,000.0

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН

ТУШААЛ

2000 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар хот

Монгол Улсын "Нягтлан бодох бүртгэлийн хууль"-ийн 4 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн **ТУШААХ** нь:

Нэг. Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн тодруулга бэлтгэх үлгэрчилсэн заавар, тодруулга хийх маягыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартад нийцүүлэн боловсруулсан энэхүү маягт, зааврыг 2000 оны 2 дугаар улирлаас эхлэн аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд

Маягт, заавар батлах тухай

нэвтрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, санхүү, эдийн засгийн бодлогын хэлтсийн дарга нарт, энэ талаар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэл, магадлагааны хэлтэс /Р.Батжаргал/, Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн зөвлөл /Л.Энх-Амгалан/-д тус тус үүрэг болгосугай.

САЙД

Я.ОЧИРСҮХ

Сангийн сайдын 2000 оны 64 тоот тушаалаар батлан

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА БЭЛТГЭХ ҮЛГЭРЧИЛСЭН ЗААВАР

Нэг. Нийтлэг зүйл.

1. Зааврын зорилго

1. Санхүүгийн тайлангийн тодруулга /СТТ/ бэлтгэх үлгэрчилсэн зааврын зорилго нь аж ахуйн нэгж, байгууллагууд НББОУС-ыг нэвтрүүлж, хэрэгжүүлэхэд болон хэрэглэгчдэд ач холбогдол бүхий мэдээлэл бэлтгэхэд нь туслах явдал юм.

2. Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн тодруулгын зорилго нь:

а/ санхүүгийн тайланг бэлтгэх тулгуур үзэл баримтлал, ажил гүйлгээ ба үйл явдлыг бүртгэхээр сонгож авсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаархи мэдээллийг илэрхийлэх

б/ санхүүгийн тайланд тусгаагүй боловч НББОУС-аар шаарддаг мэдээллийг тодруулах; в/ санхүүгийн тайлангийн үндсэн хэсэгт тусгагдсан боловч үнэн зөвөөр дэлгэрэнгүй тайлбарлах зайлшгүй шаардлагатай нэмэлт мэдээллийг тодруулах.

3. Аж ахуйн нэгж, байгууллагууд санхүүгийн тайлангийн тодруулга бэлтгэхдээ энэхүү үлгэрчилсэн зааврыг үндэс болгоно.

4. Аж ахуйн нэгж, байгууллагууд уг заавар, тодруулгын маягыг өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан өөрчлөж ашиглахыг зөвшөөрнө.

Хоёр. Санхүүгийн тайлангийн тодруулга

2. Тодруулгын бүрэлдэхүүн, гүйцэтгэх дараалал

Хэрэглэгчдээс тухайн аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг ойлгох, өөрийн хэрэгцээтэй мэдээллийг олж авах, түүнийг өөр байгууллагын санхүүгийн тайлантай харьцуулах боломжийг хангах зорилгоор тодруулгыг дараах дараалал, бүрэлдэхүүн хэсгийн дагуу хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа ба зохион

байгуулалт;

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого;

3. Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулга.

Гурав. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа ба зохион байгуулалт

1. Санхүүгийн тайлангийн тодруулгын хэсэгт тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нэр, эрхэлдэг үйл ажиллагааны гол чиглэл ба товч тодорхойлолт, балансын огноо, санхүүгийн тайлангийн хамарсан тайлант үе /Балансын өдөр/-ийг тусган харуулна. Мөн аж ахуйн нэгж, байгууллагын бүтэц зохион байгуулалт /дангаар эсвэл хэд хэдэн аж ахуйн нэгжийг хамарч буй эсэх/, байршил, байрлах газрын хаяг, хариуцлагын хэлбэр /ХХК, ХК г.м/, нийт эзэмшигчдийн өмчид төрийн болон хувийн өмчийн эзлэх хувь, харьяалах санхүү, татварын албаны нэр, тайлагнаж буй мөнгөний нэгж зэрэг илэрхий бус зүйлсийг тодруулсан байх шаардлагатай.

Дөрөв. Нягтлан бодох бүртгэлийн бодлого

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлого гэдэг нь бүртгэл хөтөлж, санхүүгийн тайланг бэлтгэж танилцуулах талаар тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас батлан мөрдөж байгаа бүртгэлийн тусгай зарчмууд, бүртгэж тайлагнах үед мөрдөгдөх арга, дүрэм журам, практик ажиллагаа юм. Эдгээр нь тухайн байгууллагын удирдлагаас баталсан дүрэм журамд тусгалаа олдог.

2. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага өөрийн бодит нөхцөлд, ялангуяа байгууллагынхаа санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнг аль болохууц үнэн зөвөөр илэрхийлэхэд нийцсэн бүртгэлийн бодлогыг сонгон авч мөрдөж ажиллах ёстой. Мөрдөж буй бүртгэлийн бодлого зохистой эсэхийг үнэлж дүгнэж, бүртгэлийн бодлогодоо өөрчлөлт оруулсан бол тэр тухайгаа тодруулгад

дурдана.

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг үндсэнд нь 2 ангилж тодруулга хийнэ. Үүнд:

- а/ Нягтлан бодох бүртгэлийн ерөнхий бодлого;
- б/ нягтлан бодох бүртгэлийн тусгай бодлого.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгыг бэлтгэхдээ санхүүгийн тайлан тусгагдсан зүүлэлтүүдийг хэрхэн бүртгэдэг аргуудаа тайлбарлах хэлбэрээр үзүүлнэ. Гэхдээ зарим зүйлсийг хүснэгтээр илэрхийлж болно.

5. Аж ахуйн нэгж, байгууллага нь жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахдаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгыг хамт бэлтгэнэ.
4.1. Бүртгэлийн ерөнхий бодлого

1. Нягтлан бодох бүртгэлийн ерөнхий бодлогод дараах зүйлийг тусгаж, тодруулганд энэ талаар тодорхой дурдана. Үүнд:

а/ санхүүгийн тайлан бэлтгэж, тайлагнах арга ажиллагаа;

б/ нягтлан бодох бүртгэлийг хөтлөх маягт, аргачлалыг сонгох;

в/ Сангийн ямнаас баталсан дансны үлгэрчилсэн зааврыг үндэслэн дансны төлөвлөгөөг боловсруулж батлан мөрдөх;

г/ Бүх төрлийн нөөц сан байгуулах арга;

д/ үйлдвэрлэлийн зардлыг бүртгэж, бүтээгдэхүүний өртгийг хэрхэн тодорхойлох арга;

е/ эзэмшигчдийн өмчийг үнэлж, бүртгэх арга;

в/ санхүүгийн тайлан бэлтгэхэд ашигласан хэмжилтийн суурь.

4.2. Нягтлан бодох бүртгэлийн тусгай бодлого

1. Санхүүгийн тайланг үнэн зөвөөр ойлгоход зайлшгүй шаардлагатай бүртгэлийн тусгай бодлогыг тодруулгад товч тайлбарлана. Эдгээр тусгай бодлогод нь тухайн байгууллага харгалзан үзэх ёстой боловч ямар нэг хязгаарлалт тогтоодоггүй. Ийм бүртгэлийн бодлогод дараах зүйлүүд хамрагдана. /Доор дурдсан тусгай бодлого бүртэй холбоотой тодотгож тайлбарлавал зохих зүйлүүдийг жагсааж бичив / Үүнд:

1. Нэгтгэх зарчим

1.1. Нэгтгэгдсэн үндсэн зарчим, толгой ба хараат компанийн тодорхойлолт, нэр, оршиж буй улс ба албан ёсны хаяг, санал өгөх эрхийн хувь хэмжээг тусгасан охин компаниудын жагсаалт.

2. Бизнесийн нэгдэл

2.1. Бизнесийн нэгдлийн үндсэн хэлбэр / худалдан авч эзэмшсэн эсвэл хөрөнгийн хувийг нэгтгэх замаар бий болсон бизнесийн нэгдлийн алин болох/;

2.2. Нэгдэж байгаа аж ахуйн нэгжийн нэр ба тодорхойлолт;

2.3. Нэгдэх үйл ажиллагаанд орсон хугацаа;

2.4. Эерэг ба сөрөг гудвилын элэгдэл тооцох арга, хугацаа, бусад тайлбар;

2.5. Тайлангийн хугацааны туршид нэмж бүртгэгдсэн болон бүрмөсөн устгагдсан эерэг сөрөг гудвилл.

3. Хамтарсан үйлдвэр

3.1. Хамтарсан үйлдвэрийн хэлбэр, бүтэц;

3.2. Хамтарсан үйлдвэрт оролцох эзэмшлийн хувь, хэмжээ;

3.3. Хамтарсан үйлдвэрийн нягтлан бодох бүртгэлийн бодлого ба санхүүгийн тайлан бэлтгэх арга.

4. Мөнгө, түүнтэй адилтгах зүйлсийн тодорхойлолт

4.1. Хязгаарлалттай ба барьцаалагдсан мөнгөн хөрөнгийн тухай тэмдэглэл;

4.2. Мөнгөтэй адилтгах зүйлс /мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай богино хугацаат хөрөнгө оруулалт, түүний дансны болон зах зээлийн үнэ гэх мэт/

5. Авлага

5.1. Найдваргүй авлагын нөөц байгуулсан арга;

5.2. Найдваргүй авлагын хасагдуулга дансны гүйлгээ болон хэдий хэмжээний авлагад хэдий хэмжээний авлагын нөөц тооцсоныг тайлбарлах.

6. Бараа материал ба өртөг тооцох арга

6.1. Бараа материалын бүртгэлийн ямар систем хэрэглэдэг /байнгын, цаг үеийн/;

6.2. Бараа материалын нөөцийн үнэлгээний арга;

6.3. Бараа материалын өртгийг тооцдог арга /ЭАЭЗ, САЭЗ, дундаж өртөг, тусгай тэмдэглэгээний арга/.

7. Биет ба биет бус хөрөнгө ба тэдгээрийн элэгдэл, үнэлгээ

7.1. Нийт үлдэгдэл өртгийг тооцоход хэрэглэсэн хэмжилтийн суурь;

7.2. Биет ба биет бус хөрөнгийн элэгдэл тооцсон арга;

7.3. Үндсэн хөрөнгийг үнэлсэн арга, худалдан авсан хөрөнгийн төлбөрийг хэрхэн хийж байгаа хэлбэр. Үүнд:

-Тодорхой хугацааны дараа хийгдэж байгаа төлбөрт тооцсон хөнгөлөлт, өнөөгийн үнэ цэнийн тооцоолол /санхүүгийн түрээсээр авсан хөрөнгө байж болно/;

-хэд хэдэн төрлийн хөрөнгийг нэгдсэн үнээр /гэрээний үнэ/ авсан байж болно.

-Төлбөрийг үнэт цаасаар төлсөн;

-Сольж авсан хөрөнгийн хувьд.

7.4. Хөрөнгийг сэргээн босгох зардлын бүртгэлийн бодлого;

7.5. Хөрөнгийг дахин үнэлэхэд ашигласан суурь;

7.6. Дахин үнэлгээ хүчин төгөлдөр болж үйлчилж эхэлсэн он, сар, өдөр;

7.7. Үнэлгээнд гадны эксперт оролцуулсан эсэх;

7.8. Нөхөлтийн өртөг тооцоход хэрэглэсэн индексүүд, тэдгээрийн үндэслэл.

8. Орлогыг хүлээн зөвшөөрөх

8.1. Орлого тодорхойлох, хүлээн зөвшөөрөх, хэмжих, бүртгэхэд баримталсан бодлого;

8.2. Орлого бий болгох хугацаа;

8.3. Орлоготой холбогдох болзошгүй зүйлс.

9. Орлогын татвар ба хойшлогдсон татвар

9.1. Орлогын татвар болон хойшлогдсон орлогын татварын тодорхойлолт /нягтлан бодох бүртгэлийн бодлого болон татварын хуулийн дагуу хойшлогдсон татварын хөрөнгө эсвэл өглөгийг хэрхэн бүртгэдэг арга/;

9.2. Орлогын тайлангийн татвар төлөхийн өмнөх ашгийг татвар ногдох ашигтай зохицуулсан шинжилгээ.

10. Гадаад валютын ажил гүйлгээ

10.1. Орлогын тайланд илэрхийлсэн ханшийн зөрүүгийн ашиг, алдагдлын дүн;

10.2. Боломжит сонголтот аргыг баримтлан хөрөнгийн дансын үнэнд шингээсэн тайлангийн үед үүссэн ханшийн зөрүүгийн алдагдлын дүн. Хүчтэй девальваци болон валютын үнэгүйдлийн үед гадаад валютаар нэхэмжлэгдсэн худалдан авалттай холбогдох үр төлбөрийн ханшийн зөрүүг холбогдох хөрөнгийн дансанд шингээж болохыг боломжит сонголтот /альтернатив/ арга гэнэ;

10.3. Гадаад үйл ажиллагаа болон гадаад дахь аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг валютад хөрвүүлэхэд ашигласан арга;

10.4. Валютын гүйлгээ ихтэй аж ахуйн нэгжийн хувьд ханшийн зөрүүгийн талаархи тайлбар;

10.5. Балансад капитал гэж ангилсан ханшийн зөрүүгийн цэвэр дүн.

11. Онцгой үйл ажиллагаа, алдаа, бүртгэлийн бодлогын өөрчлөлт

11.1. Онцгой үйл ажиллагааны шинж байдал, нөлөөлөл, түүний давтамж /хөрөнгийг албадан хураах, тараах, байгалийн гамшиг/;

11.2. Зогсоосон үйл ажиллагаа, түүний арга хэлбэр /худалдах, татан буулгах /гасалбар болсон хугацаа, тасалдлаас үүссэн алдагдал/;

11.3. Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, түүнд хийсэн залруулга;

11.4. Материаллаг алдаа.

12. Санхүүгийн хэрэглүүр

12.1. Санхүүгийн хэрэглүүрүүдэд учирч болох эрсдэлийн тодруулга. Үүнд:

а/ Үнийн эрсдэл. Энэ нь мөнгөн эрсдэл, хүүгийн түвшний эрсдэл, зах зээлийн эрсдэл гэсэн 3 төрөлтэй;

б/ зээлийн эрсдэл;

в/ төлбөрийн чадварын эрсдэл;

г/ мөнгөн гүйлгээний эрсдэл.

12.2. Гадаад валютын ханшийн хэлбэлзлийн эрсдэл.

13. Түрээс

13.1. Түрээсийн ангилал /санхүүгийн, үйл ажиллагааны/;

13.2. Түрээсийн орлого хуваарилтад ашиглаж байгаа арга.

14. Судалгаа хөгжлийн зардал

14.1. Судалгаа хөгжлийн зардалд хэрэглэсэн бүртгэлийн бодлого;

14.2. Элэгдэл тооцоход хэрэглэсэн арга;

14.3. Элэгдэл тооцох хугацаа, эсвэл

хасагдуулгын хувь.

15. Хөрөнгө оруулалт, түүнийг бүртгэх арга

15.1. Хөрөнгө оруулалтын балансын үнийг тодорхойлох;

15.2. Зах зээлийн үнээр бүртгэсэн богино хугацаат хөрөнгө оруулалт болон худалдах хөрөнгө оруулалтын зах зээлийн үнэнд гарсан өөрчлөлт;

15.3. Урт ба богино хугацаат хөрөнгө оруулалтын хүү, ногдол ашиг;

15.4. Борлогдохгүй хөрөнгө оруулалтын боломжит үнэ, өртгийн үнэлгээний арга;

15.5. Дахин үнэлгээ хийх хугацааны талаархи бодлого, сүүлчийн дахин үнэлгээ хийсэн он, сар, өдөр.

16. Барилгын ажлын гэрээ

16.1. Тухайн тайлант үеийн гэрээний орлогыг тодорхойлох болон гэрээний дуусаагүй ажлын үе шатыг тодорхойлоход ашигласан арга.

17. Зээлжилтийн зардал

17.1. Зээлжилтийн зардлын бүртгэлийн бодлого

18.1. Болзошгүй болон балансын дараах үйл явдал

18.1. Болзошгүй үйл явдлын мөн чанар, санхүүгийн нөлөөллийн үнэлгээ, эсвэл тийм үнэлгээ хийж болохгүй тухай үндэслэл;

18.2. Балансын дараах үйл явдал, түүний шинж чанар, санхүүгийн нөлөөллийн тооцоолол, өгсөн үнэлгээ, тайлбар.

19. Засгийн газрын татаас

19.1. Улсын татаасыг бүртгэх бодлого, санхүүгийн тайланд тусгах арга;

19.2. Үр өгөөжийг нь шууд хүртэж байгаа бусад төрлийн улсын тусламжийн тухай;

19.3. Хүлээн зөвшөөрсөн улсын тусламжинд дагалдсан биелэгдээгүй нөхцөл болзол болон бусад санамсаргүй тохиолдох зүйлс.

5. Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулга

1. Энэхүү нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн /баланс, орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан/ хэсгүүдийн утга агуулгыг дэлгэрэнгүй илэрхийлж танилцуулах болон санхүүгийн тайланд тусгагдаагүй боловч НББОУС-аар шаарддаг мэдээллийг тодруулахад туслах явдал юм.

2. Санхүүгийн тайлангийн үндсэн хэсгүүдийн нэмэлт тодруулгыг хавсралт маягтын дагуу жилд нэгээс доошгүй удаа гаргаж, санхүүгийн тайлангийн хамт харьяалах санхүүгийн байгууллагад тушаана.

3. Санхүүгийн тайлангийн тодруулгын маягууд

Үүнд:

А. Эргэлтийн хөрөнгө

1. Мөнгөн хөрөнгө

а/ бэлэн мөнгө /СТТ-1а/;

б/ харилцахад байгаа мөнгө /СТТ-1б/;

в/ богино хугацаат хөрөнгө оруулалт /СТТ-1в/.

2. Авлага

а/ авлагын ангилал /СТТ-2/;

3. Бараа материал

а/ хуучирсан бараа материалын хасагдуулга /

СТТ-3а/;



- б/ эргэлтийн сүргийн мал, амьтад /СТТ-35/;
- Б. Эргэлтийн бус хөрөнгө
- 4. Биет хөрөнгө
 - а/ үндсэн хөрөнгө болон элэгдлийн өөрчлөлт /СТТ-4а/;
 - б/ Дуусаагүй барилга /СТТ-4б/;
 - в/ үндсэн сүргийн мал, амьтад /СТТ-4в/;
- 5. Биет бус хөрөнгө
 - а/ биет бус хөрөнгө ба элэгдэл /СТТ-5/
- 6. Урт хугацаат хөрөнгө оруулалт
 - а/ урт хугацаат хөрөнгө оруулалтын /СТТ-6
- В. Өр төлбөр
- 7. Урт ба богино хугацаат өр төлбөр а/ богино хугацаат өрийн ангилал /СТТ-7а/;
- б/ урт хугацаат өрийн ангилал /СТТ-7б/.
- Г. Эздийн өмч
- 8. Эздийн өмч

- а/ хувьцаат капитал /СТТ-8/
- Д. Орлого, зардал
- 9. Орлого зарлага
 - а/ хойшлогдсон орлого /СТТ-9а/;
 - б/ онцгой шинжтэй орлогын ангилал /СТТ-9б/;
 - в/ онцгой шинжтэй зарлагын ангилал /СТТ-9в/;
 - г/ судалгаа зохион бүтээх зардал /СТТ-9г/.
- 4. Дээрх маягтад ороогүй боловч НББОУС-таар шаарддаг зүйлүүдийн тодруулгыг аж ахуйн нэгж, байгууллагууд өөрийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулж тайлбар болон хүснэгтээр нэмж гаргана.
 - б. Бусад нэмэлт тодруулга
 - 1. Борлуулсан бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний нэр, төрөл, тоо, үнийн дүн;
 - 2. Борлуулсан бүтээгдэхүүний өөрийн өртгийн тооцоо;
 - 3. Ажиллагсдын тоо, цалин хөлсний тооцоо.

Сангийн сайдын 2000 оны 64 тоот тушаалаар батлав.

Сангийн Яамны Нягтлан бодох бүртгэл, магадлагааны хэлтэс

.....-ийн.....оны.....улирлын
/байгууллагын нэр/
санхүүгийн тайлангийн тодруулга

1. Байршил.....аймаг, хот.....сум /дүүрэг/
.....баг /хороо/,.....байрлах газрын хаяг
 2. Хариуцлагын хэлбэр.....
 3. Өмчийн хэлбэр: Төрийн.....хувь, хувийн.....хувь
 4. Аль аймаг, хот, дүүрэг, сумын санхүү, татварын албанд харьяалдаг.....
 5. Балансын тайлант үеийн хамарсан хугацаа /балансын өдөр/ онысарын.....ний өдрөөсонысарын.....өдөр
 6. Эрхэлдэг үйл ажиллагааны гол чиглэл:
 - а/.....
 - б/.....
 - в/.....
 - г/.....
 7. Санхүүгийн тайлан нь аж ахуйн нэгжийг дангаар нь эсвэл хэд хэдэн аж ахуйн нэгжийг хамарч байгаа эсэх.....
 8. Тайлагнаж буй мөнгөний нэгж.....
 9. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийн нарийвчлалын түвшин.....
- Дарга /захирал/...../...../
- Ерөнхий санхүүч...../...../

А.Эргэлтийн хөрөнгө

 1. Мөнгөн хөрөнгө
 Бэлэн мөнгө

СТТ-1а

Валютын төрөлсарын...-ны үлдэгдэл	Валютын ханш	Дүн /төгрөгөөр/

Харилцахад байгаа мөнгө СТТ -1б

Валютын төрөлсарын...-ны үлдэгдэл	Валютын ханш	Дүн /төгрөгөөр/	Хязгаарлалттай ба барьцаалагдсан тухай тэмдэглэл

Богино хугацаат хөрөнгө оруулалт СТТ-1в

Богино хугацаат хөрөнгө оруулалтын нэр төрөлсарын...-ны үлдэгдэл	Нэг бүрийн дансны үнэний өдрийн нэг бүрийн зах зээлийн үнэ	Дүн /төг/	Зах зээл үнэ

2. Авлага

Авлагын ангилал

СТТ-2

	Үзүүлэлт	Байгууллага, хүмүүсийн тоо	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Дансны авлага			
2	Компани хоорондын авлага			
3	Захирлуудаас авах авлага			
4	Ажилчин, албан хаагчдаас авах авлага			
5	Бусад байгууллага, хүмүүсээс авах авлага			
6				
7	Хүүгийн авлага			
	Дүн			

3. Бараа материал

Хуучирсан бараа материалын хасагдуулга

СТТ-3а

Бараа, материалын төрөлсарын...-ны үлдэгдэл	Хасагдуулга		
		хоцрогдолд орсон	чанар муудсан	хуучирсан

Тайлбар: Бараа материалын хоцрогдлын хасагдуулга нь хоцрогдсон, хуучирсан, чанар муудсан бараа материалыг тооцон үзсэний үндсэн дээр байгуулагддаг.

Урьдчилж төлсөн зардал: Урьдчилж төлсөн зардлын төрлөөр тодруулга хийнэ. Хэдэн сар, жилийн татвар эсвэл даатгалыг урьдчилан төлсөн тухай мэдээллийг бичнэ.

Эргэлтийн сүргийн мал, амьтад

СТТ-3б

Малын төрөл	Оны эхний үлдэгдэл	Орлого Дүн	Зарлага Дүнсарын...-ний үлдэгдэл



- б/ эргэлтийн сүргийн мал, амьтад /СТТ-3б/;
- Б. Эргэлтийн бус хөрөнгө
- 4. Биет хөрөнгө
 - а/ үндсэн хөрөнгө болон элэгдлийн өөрчлөлт /СТТ-4а/;
 - б/ Дуусаагүй барилга /СТТ-4б/;
 - в/ үндсэн сүргийн мал, амьтад /СТТ-4в/;
- 5. Биет бус хөрөнгө
 - а/ биет бус хөрөнгө ба элэгдэл /СТТ-5/
- 6. Урт хугацаат хөрөнгө оруулалт
 - а/ урт хугацаат хөрөнгө оруулалтын /СТТ-6
- В. Өр төлбөр
- 7. Урт ба богино хугацаат өр төлбөр а/ богино хугацаат өрийн ангилал /СТТ-7а/;
- б/ урт хугацаат өрийн ангилал /СТТ-7б/.
- Г. Эздийн өмч
- 8. Эздийн өмч

- а/ хувьцаат капитал /СТТ-8/
- Д. Орлого, зардал
- 9. Орлого зарлага
 - а/ хойшлогдсон орлого /СТТ-9а/;
 - б/ онцгой шинжтэй орлогын ангилал /СТТ-9б/;
 - в/ онцгой шинжтэй зарлагын ангилал /СТТ-9в/;
 - г/ судалгаа зохион бүтээх зардал /СТТ-9г/.
- 4. Дээрх маягтад ороогүй боловч НББОУС-таар шаарддаг зүйлүүдийн тодруулгыг аж ахуйн нэгж, байгууллагууд өөрийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулж тайлбар болон хүснэгтээр нэмж гаргана.
 - б. Бусад нэмэлт тодруулга
 - 1. Борлуулсан бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний нэр, төрөл, тоо, үнийн дүн;
 - 2. Борлуулсан бүтээгдэхүүний өөрийн өртгийн тооцоо;
 - 3. Ажиллагсдын тоо, цалин хөлсний тооцоо.

Сангийн сайдын 2000 оны 64 тоот тушаалаар батлав.

Сангийн Яамны Нягтлан бодох бүртгэл, магадлагааны хэлтэс

.....-ийн.....оны.....улирлын
/байгууллагын нэр/
санхүүгийн тайлангийн тодруулга

- 1. Байршил.....аймаг, хот.....сум /дүүрэг/
.....баг /хороо/,.....байрлах газрын хаяг
- 2. Хариуцлагын хэлбэр.....
- 3. Өмчийн хэлбэр: Төрийн.....хувь, хувийн.....хувь
- 4. Аль аймаг, хот, дүүрэг, сумын санхүү, татварын албанд харьяалдаг.....

5. Балансын тайлант үеийн хамарсан хугацаа /балансын өдөр/ онысарын.....ний өдрөөсонысарын.....өдөр

6. Эрхэлдэг үйл ажиллагааны гол чиглэл:

- а/.....
- б/.....
- в/.....
- г/.....

7. Санхүүгийн тайлан нь аж ахуйн нэгжийг дангаар нь эсвэл хэд хэдэн аж ахуйн нэгжийг хамарч байгаа эсэх.....

8. Тайлагнаж буй мөнгөний нэгж.....

9. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийн нарийвчлалын түвшин.....

Дарга /захирал/...../...../
Ерөнхий санхүүч...../...../

А.Эргэлтийн хөрөнгө
1. Мөнгөн хөрөнгө

Бэлэн мөнгө

СТТ-1а

Валютын төрөлсарын...-ны үлдэгдэл	Валютын ханш	Дүн /төгрөгөөр/

Харилцахад байгаа мөнгө СТТ -1б

Валютын төрөлсарын...-ны үлдэгдэл	Валютын ханш	Дүн /төг- рөгөөр/	Хязгаарлалттай ба барьцаалагд- сан тухай тэмдэглэл

Богино хугацаат хөрөнгө оруулалт СТТ-1в

Богино хугацаат хөрөнгө оруула- лтын нэр төрөлсарын..... -ны үлдэгдэл	Нэг бүрийн дансны үнэний өдрийн нэг бүрийн зах зээлийн үнэ	Дүн /төг/ Дансны үнэ	Зах зээл үнэ

2. Авлага

Авлагын ангилал

СТТ-2

	Үзүүлэлт	Байгууллага, хүмүүсийн тоо	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Дансны авлага			
2	Компани хоорондын авлага			
3	Захирлуудаас авах авлага			
4	Ажилчин, албан хаагчдаас авах авлага			
5	Бусад байгууллага, хүмүүсээс авах авлага			
6				
7	Хүүгийн авлага			
	Дүн			

3. Бараа материал

Хуучирсан бараа материалын хасагдуулга

СТТ-3а

Бараа, материалын төрөл	...сарын... -ны үлдэгдэл	Хасагдуулга		
		хоцрогдолд орсон	чанар муудсан	хуучирсан

Тайлбар: Бараа материалын хоцрогдлын хасагдуулга нь хоцрогдсон, хуучирсан, чанар муудсан бараа материалыг тооцон үзэсний үндсэн дээр байгуулагддаг.

Урьдчилж төлсөн зардал: Урьдчилж төлсөн зардлын төрлөөр тодруулга хийнэ. Хэдэн сар, жилийн татвар эсвэл даатгалыг урьдчилан төлсөн тухай мэдээллийг бичнэ.

Эргэлтийн сүргийн мал, амьтад

СТТ-3б

Малын төрөл	Оны эхний үлдэгдэл	Орлого Дүн	Зарлага Дүн	...сарын... -ний үлдэгдэл

Б. Эргэлтийн бус хөрөнгө

4. Биет хөрөнгө

 Үндсэн хөрөнгө болон элэгдлийн өөрчлөлт СТТ-4а

Хөрөнгийн ангилал	...оны...сарын ...ны үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	...оны...сарын...ний үлдэгдэл

Түрээсийн үндсэн хөрөнгө: Бусдад түрээслүүлсэн болон бусдаас түрээслэн ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн тоо, мөнгөн дүн, өмчлөх эрхийн хязгаарлалтын талаар тодруулга хийнэ.

Дуусаагүй барилга

СТТ-4б

Дуусаагүй барилгын нэр	Дуусгалтын хувь	Нийт төсөвт өртөг	Ашиглалтанд орох эцсийн хугацаа

Үндсэн сүргийн мал, амьтад

СТТ-4в

Малын төрөл	Оны эхний үлдэгдэл	Орлого Дүн	Зарлага Дүн	...сарын...ний үлдэгдэл

5. Биет бус хөрөнгө

 Биет бус хөрөнгө ба элэгдэл СТТ-5

Биет бус хөрөнгийн нэр	Анхны өртөг	Элэгдэл тооцсон хугацаа	...оны...сарын...ний үлдэгдэл өртөг	Тайланг хугацаанд байгуулсан элэгдэл

Тайлбар: Биет бус хөрөнгө нь юунаас үүссэн, ямар хугацаатай болохыг товч тайлбарлана.

6. Урт хугацаат хөрөнгө оруулалт ба авлага

Урт хугацаат хөрөнгө оруулалт

СТТ-6

Хөрөнгө оруулалтын төрөл	...сарын...ний үлдэгдэл	Тайланг хугацааны ногдол ашиг

В. Өр төлбөр

7. Богино хугацаат өр төлбөр

 Богино хугацаат өрийн ангилал СТТ-7а

	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Дансны өглөг		
Захирлуудад өгөх өр		
Ажиллагчдад өгөх өглөг (цалин)		
Гадны хүмүүст өгөх өглөг		
Зээлийн өр		
Бусад өглөг		
Хүүгийн өр		
Дүн		

Урт хугацаат өр төлбөр

СТТ-7б

Өрийн ангилал	Анхны өрийн хэмжээ валют төгрөг	Төлөгдөж дуусах эцсийн хугацаа	Тайлант жилд төлсөн өр валют төгрөг	...сарын...ны үлдэгдэл

Г.Эзэмшигчдийн өмч

8. Эзэмшигчдийн өмч

СТТ-8

Хувьцааны төрөл	Зөвшөөрөгдсөн	Гаргасан	Нэгжийн нэрлэсэн үнэ	Нэгжийн зах зээлийн үнэ

Д.Орлого, зарлага

Хойшлогдсон орлого

СТТ-9а

Орлогын нэр	Орлогын дүн	Тайлбар

Онцгой шинжтэй орлого

СТТ-9б

Орлогын нэр	Орлогын дүн	Тайлбар

Онцгой шинжтэй зарлага

СТТ-9в

Зарлагын нэр	Зарлагын дүн	Тайлбар

Судалгаа зохион бүтээх зардал

СТТ-9г

Зардлын нэр	Тухайн ажлын эхэлсэн он	Зардлын эхний үлдэгдэл	Тайлант онд гарсан зардал	Тайлант онд зардалд хуваарилсан	...сарын...ны үлдэгдэл

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487